

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

THE ROOTS OF CRIMES RELATED TO THE ILLEGAL CIRCULATION OF DRUGS IN MONGOLIA

Пүрэвврагчаагийн Өлзийтогтох*

Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн хошууч

Pol. Maj. Ulziiitogtokh Purevragchaa, Ph.D Candidate, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: ulziiulzii354@gmail.com

Хураангуй: Хүн амын өсөлтөд эрүүл мэнд, эдийн засаг, амьжиргааны түвшин, хүнсний үйлдвэрлэл, тэжээлийн сайжруулалт, хотжилт, шилжилт хөдөлгөөн, нийгмийн тогтолцоо зэрэг олон зүйлээс хамааралтай бөгөөд үүнээс эрүүл мэндийн асуудал чухал нөлөөлөл үзүүлдэг нь мэдээж. Хүний эрүүл мэндийн аюулгүй байдалд эм, эмийн бүтээгдэхүүний чанар, хүртээмж, хяналтын тогтолцоо шууд нөлөө үзүүлнэ.

Энэ нөхцөл байдалд тулгуурлан зарим төрлийн эм, эмийн бүтээгдэхүүн, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл өндөр үнэтэй, бизнес болгон ашиглахад орлого ихтэй байдаг. Үүний улмаас хуурамч эм үйлдвэрлэх, зөвшөөрөлгүй борлуулах, импортлох, экспортлох, түгээх зэрэг хууль бус үйл ажиллагаа нэмэгдэж байна.

Иймээс эм, эмийн бүтээгдэхүүний хууль бус эрэлт, нийлүүлэлтийн асуудлыг судалж тодорхойлохыг зорьсон. Энэ хүрээнд монголын уламжлалт анагаах ухааны түүх болон эмийн хууль бус худалдаа, түүнтэй холбоотой /хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах/ гэмт хэргийн үүсэл хөгжил, хөгжлийн үе шат, түүхэн уламжлал, нийгмийн зохицуулалт, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийлээ.

Abstract: Due to various social factors, population growth has increased. It is influenced by multiple factors, including healthcare, the economy, living standards, food production, nutritional improvements, urbanization, migration, and social structures. Among these, healthcare plays a crucial role. The safety of human health is directly affected by the quality, availability, and regulatory control of medicines and pharmaceutical products.

Based on this situation, certain types of medicines, pharmaceutical products, biopreparations, and medical supplies are highly priced and generate significant profits in the business sector. As a result, illegal activities such as counterfeit drug production, unauthorized sales, imports, exports, and distribution have been on the rise.

Therefore, this study aims to analyze and identify issues related to the illicit demand and supply of medicines and pharmaceutical products. Within this framework, it examines the history of traditional Mongolian medicine and the illegal pharmaceutical trade. The study also explores the origins and development of crimes associated with the illegal production, export, import, distribution, and sale of medicines, raw pharmaceutical materials, biopreparations, and medical devices, along with their historical evolution, social regulation, and legal framework.

Түлхүүр үгс: Эм, хууль бус, гэмт хэрэг, түүхэн уламжлал.

Keywords: Medicine, illegal, crime, historical tradition /roots/.

Удиртгал

Эмийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн түүхэн уламжлал, үүсэл хөгжлийг дурдахын өмнө Монголын анагаах ухаан, эм, эмийн бүтээгдэхүүн, эмийн бодис түүнтэй холбоотой асуудлыг хөндөх нь зүйтэй. Учир нь эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл цаг хугацааны явцад хөгжихийн зэрэгцээ түүнтэй холбоотой эрх зүйн орчин бий болж, улмаар дагаж үйлдэгдэх гэмт хэрэг хувьсан өөрчлөгддөг.

Эм нь олон зуун жилийн түүхтэй бөгөөд хүмүүст эрт дээр үеэс эхлэн ургамал, амьтан, эрдсийн гаралтай зүйлийг эмчилгээнд хэрэглэж байжээ. Хүн төрөлхтөн тэр үед эмчилгээний чанартай байгалийн зүйлийг ямар ч өөрчлөлтгүйгээр тэр хэвээр нь хэрэглэдэг байлаа. Цаашлаад хүний оюун ухаан хөгжихийн хирээр байгаль дахь эмийн зүйлийг нунтаглах, чанах зэргээр боловсруулж хэрэглэх болов. (Уранчимэг, 2006)

Эмийн хууль бус эргэлттэй холбоотой эрх зүйн хөгжлийг гурван үечлэлд хуваан авч үзлээ. Энэ нь анагаахын болоод хууль зүйн хөгжлийн түүхийн эх сурвалж бүтээлүүдийг харгалзсан болно. Үүнд: **Нэгдүгээр үечлэл** буюу “Эртний үе”, **хоёрдугаар үечлэлд** Богд хаант Монгол Улсаас Ардчилсан Монгол Улс хүртэлх, **гуравдугаар үечлэлд** Ардчилсан Монгол Улсаас өнөөг хүртэлх цаг үеийн баримт, эрх зүйн хэм хэмжээг хамаарууллаа.

Түүхийг бүтээх, үечлэхэд хамгийн их итгэл үнэмшил төрүүлэх нотолгоо бол археологийн олдворууд юм. Археологийн олдворууд нь бичиг үсэг бий болж түүгээр мэдээлэл дамжихаас өмнөх түүхийн үйл явдлын бодитой гэрч юм. (Болд, 2006).

Монголын уламжлалт анагаах ухааны түүх бол 5000 орчим жилийн өмнөөс эхлэлтэй хэмээн эрдэмтэд үзсэн байна.

Үндсэн хэсэг

Нэгдүгээр үечлэл /Эртний үе/:

Монголчууд эрт дээр үеэс өвчин эмгэгийг илааршуулахад ургамал, амьтны болон эрдсийн гаралтай түүхий эдийг ашиглан эм тан хийх, ханах, төөнөх, хатгах, жигнэх, бигнэх, барих, эвлүүлэх, зэрэг олон аргыг хэрэглэж ном сударт тэмдэглэж ухаант ардын дунд уламжлагдаж иржээ. (Уранчимэг, 2006)

Монголчууд тархины мэс засал хийж байсны гэрч болох Увс аймгийн Улаангом сумын Чандмань уулын булшнаас олдсон өрөмдөлт бүхий гавлын яс гарсныг батлах баримт юм. Жишээлбэл "Хог бүг" зохиолд Лэгважалцангийн эшлэл болгон авсан "Нүүдэлчдийн дуулга нэвтлэх 35 янзын арга" гэдэг мэс заслын мэт эмчилгээний талаар дурдсан байдаг.

Хүрэл зэвсгийн үед Археологичдын малтан илрүүлсэн хүрлийн сүүлч төмрийн эхэн үед хамаарагдах Чандмань уулын булшнаас гарсан нийт 156 хүний гавлын 108 яс, 99 урт мөчний ясыг шинжлэн 20 төрлөөр ялган оношилжээ. Чандманьчуудын дотор шүдний уналт, шүд цоорох өвчин, эрүүний углуургын үрэвсэл, шүдний буруу ургалт, буйлны үрэвсэл, идээт үрэвсэл, хортой, хоргүй хавдар илэрчээ. Гэхдээ шүдний өвчлөлт нь судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн материалтай харьцуулахад бага байгаа нь тогтоогджээ.

Энэ нь “Хуан Ди Нэйжин” судрын "Тэндэх нутгийн иргэд задгай уур амьсгалд байнга нүүдэллэн байгальд шүтэн амьдардаг. Тэдний хоол хүнс нь мах, сүүн бүтээгдэхүүнээс бүрддэг" гэдэгтэй нийцэн калыци ихтэй



МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТҮҮХ



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ

цагаан идээ, махыг байнгын хэрэглээгээ болгосон нь хүмүүс шүдний янз бүрийн өвчлөлөөр өвдөх нь бага байжээ. Гавал ясны бусад гэмтлийн хувьд хугарлын эдгэрэлтийн шинжээр 70 хувь нь зөв бороолж эдгэрсэн нь Баруун Монголын нутагт иргэншиж байсан Чандмань хэмээх нүүдэлчин овог аймгийн дунд хугарал гэмтлийг эмчлэх бариа заслын арга ухаан байсныг гэрчлэх тод баримт юм.

Хүннү, Сяньби, Жужан Түрэг, Уйгар Хятан улсын үед Монголын анагаах ухаан, эмч, эм, түүнтэй холбоотой анагаагч бодисууд түүхийн хугацаанд хөгжин иржээ. Монгол Улсад хүн оршин суурьших цагаас эхлэн Их Монгол улс байгуулагдах хүртэлх хугацаанд эмнэлгийн тусламжийн туршлага хуримтлагдан, анагаах эмч бий болж хануур, төөнүүр, хатгах, огтлох эмийн эмчилгээний аргууд хэрэглэгдэж байсан бөгөөд түүхийн эх сурвалжуудад эмнэлгийн тусламж үзүүлээгүй, эсвэл буруу эмчилсэн эмч, оточ, домч нарт ямар хариуцлага хүлээлгэдэг байсан талаар нарийвчлан тусгагдаагүй байна.

Монголчуудын төр хууль-цааз, заншлын хэм хэмжээ эртний уламжлалтай, хүчирхэг төр улс, ёс журамтай улс бөгөөд Их Монгол Улсын үеэс буюу “Их засаг” хууль, цаазад эмч, өвчтөнийг эмчлэх, буруу эмчилбэл хариуцлага хүлээлгэх, эмчилбэл шагнаж урамшуулахтай холбоотой харилцаа институцлэгдэж, эрх зүйн хэм хэмжээний хувьд хуульчлагдаж ирсэн байна.

Их Монгол Улсын үед: Чингис хаан эм, эмнэлгийн ажлыг чухалчилж үздэг байсан бөгөөд олон удаагийн дайны талбар дээр хүнд шархадсан цэргийн жанжин цэргүүдийн шарханд мэс ажилбар хийх талаар тусгайлан зарлиг буулгаж эмнэлгийн тусламж

үйлчилгээ үзүүлдэг байв. (Азжаргал, 2018)

“Их засаг” хуульд өвчлөл, эмч, тантай холбоотой зүйлүүдийг дараах байдлаар тусгажээ. Үүнд: Шалган байцаах үеэс өвчилж үхсэн цэргийн олон цөөнийг харгалзан өвчин анагаах түшмэлийн шан хийгээд ялыг тогтоон шийтгэх болой”. “Их засаг” хуульд өвчлөл, эмч, эм тантай холбоотой ийм тодорхой заалт орсон нь тухайн үед анагаах ухааны тогтолцоо бүрэлдэж, эмнэлгийн тусламжийн хэрэгцээ, шаардлага өндөрсөн эрүүлжүүлэх үйл ажиллагааны үндсэн хэсэг болж чадаж байсны гэрч юм. (Болд, 2006)

Тэр ч бүү хэл эмнэлгийн тусламжийг чанартай үзүүлж чадсан эмч түшмэлийг шагнаж урамшуулдаг, эс чадсан нэгэнтэй нь ял хэлэлцдэг байжээ. Чингис хаан гадагшаа дайнд мордвол түр буудлын ордныг сахих шадар цэргийн дотор эмнэлгийн тусламжийн ажлыг хариуцах хүн томилдог байв. Жишээлбэл: 1204 онд Чингис хаан Найман аймагтай байлдахаар мордох үед цэргийн дотроос 80 шилдэг цэргийг сонгон, түр буудлын ордныг сахих тусгай шадар цэрэг болгон томилж, уг цэргүүдээс тусгай хүнийг томилон эм, эмнэлгийн ажлыг хамааруулж байжээ.

Их засаг хуулийн 25 дугаар зүйлд “Шашны хэргэмтэн шавь нар, эмч сурагчаас бусад ард иргэд гааль гувчуур тушаах үүрэгтэй”, “Шашны хувраг, шавь, эмч отчоос бусад ард иргэд гаалийн алба, татвар төлбөл зохино (Ням-Осор, 2022) хэмээн тусгасан.

Цэргийг засах тухай цаазын 5-д Цэргийн дотор өвчилсөн цэрэг байх аваас даруй сайн отчид үзүүлж эм уулган анагааваас зохимуй. Жигүүр тус бүр сайн хүнийг сонгон сувилуулах бөгөөд жигүүрүүдээс тогтмол хүнийг гаргуулан авах тул албыг харгалзан өвчнийг дагнан сувилах бөгөөд өвдсөн

цэрэг сэхэн илаарьшсан цагт сая халаа харуулд нөхөн илгээх бөгөөд түүний тоог уг жигүүрт нь зохисыг үзэн мэдэгдвээс зохимуй. Шалган байцаах үеэс өвчилж үхсэн цэргийн олон цөөнийг харгалзан өвчин анагаах түшмэлийн шан хийгээд ялыг тогтоон шийтгэх болой. (Ням-Осор, 2022)

Алба гувчуурын цаазад Чингис хаан Абудорногийн отгуудын аливаа гувчуур албан үүргээс хэлтрүүлсүгэй хэмээн зарлиг болгов. Бас бадарчин хүн, ирдэвчин, заргач, эмч, эрдэмтэн авч ном бясалгах буюу даяанчлан явагчид хар лам, шарил ариутгагч тэргүүтэн мөн дээр лугаа адил. (МУУИС, 1995)

Дээрх бүгдээс үзэхэд энэ үед анагаах ухаан, эмчилгээ нь цэргийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой болсон бөгөөд Чингис хаан болон түүний удирдлага доор цэргийн эмнэлгүүд, эмч нар болон бөөн нарыг төрийн зүгээс дэмжиж байжээ.

Чингис хаан анагаах ухаан, эмнэлгийн тусламжийг хуульчлан зохицуулж, "Их засаг" хуульд өвчний эсрэг арга хэмжээ, эмч нарын үүрэг, тантай холбоотой асуудлыг тусгасан нь түүний эмнэлгийн тусламжийг чухалчлан үзэж байсан нэгэн илрэл юм. Мөн "Их засаг" цаазад эмч, өвчин, эмчлэх, түүнтэй холбоотойгоор урамшуулах, эмчилж чадаагүйг нь шийтгэх зэрэг эрх зүйн хэм хэмжээг анх тусган өгч, хуульчилж, зөвхөн цэргийн стратеги, удирдлагын талаар төдийгүй анагаах ухаан, эмнэлгийн салбарт ч өндөр ач холбогдол өгч, үүнийг бүхэл бүтэн улс оронд чухал хэсэг болгожээ.

Юан Улсын үед: Хубилай хааны үе бол Монголын Уламжлалт анагаах ухаан эрчимтэй хөгжиж ирсэн үе бөгөөд төрийн зүгээс нэлээд цэгцтэй бодлого явуулж, эмч нар нийгэмд томоохон байр суурь эзэлж байсан.

Хубилай хаан 1260 онд Тай Э Юан гэх эм эмнэлгийн захиргааны газрыг байгуулан мөнгөн тамга өгч эм, эмнэлгийн хэрэг явдлыг шийдэх, эмт бодисыг өргөн барих, эмийн хорооны эмч нарыг захирах зэрэг хэрэг явдлуудыг эрхлүүлсэн байна. (Болд, 2006)

Мөн 1269 онд эм барих түшмэлийг томилон эл газар орноос ирсэн ховор эм, эрдэнийн эм ба өвсөн эмийг хариуцуулах, эм тан үйлдэх явдлыг хамааруулж, 1270 онд Араб маягийн эмнэлгийн хороог байгуулж, Араб эмчийн найруулсан Сартуулын эмээр Юань улсын Нийслэлийг цагдах цэрэг болон албаны хүмүүсийн өвчнийг засуулж байжээ. Энэ эмнэлгийг **"Сартуулын эмт бодисын хороо"** гэдэг байжээ.

1273 онд эм барих товчоог томилон их нийслэл болон Гүл хөх хошуун дахь зуслангийн нийслэл хоёрын эмт бодисыг хангах явдлыг хариуцуулжээ. Бас хааны агь, авхай нарт үйлчлэх тусгай эм, эмнэлгийн байгууламжтай байсан. Тэдгээр захиргааны газарт янз бүрийн дэсийн хэдэн арван түшмэлийг томилон хэрэг эрхлүүлсэн байна. Ди Юаны зургаадугаар онд хааны эмийн хороо байгуулж 5 дугаар дэсийн ноён томилж хааны хэрэглэх үнэт чухал эмийг найруулж байсан нь түүхийн баримтуудад тусгагдан үлджээ. Мөн **Шандын эмийн товчоо гэж байжээ.** Тухайн үед үнэт эмүүдийг Шандад хадгалан хэрэглэх ажээ.

Өнчнийг тэтгэх яам энэ байгууллага нь дайн байлдаанд үрэгдсэн гавьяатай хүмүүсийн эхнэр, хүүхдийг өргөн тэтгэж, өвчин эмгэгийг нь эмчилдэг байв.

Хишгийг түгээх яам гамшиг нүүрлэсэн оронд хувцас, амуу будаа тараадаг газар. Тухайлбал Шандунд 3 жил дараалан бороо оролгүй ган болж,





Хууль сахиулахуй

хижиг өвчин дэлгэрсэнд хаан Хишгийг түгээх яаманд зарлиг болгож эм тан гарган өгчээ.

Мөн Юан улсын үед төрийн албан хаагчдын эрүүл байдлыг онцгой анхааран үзэж шинжилгээний албан ёсны мэдүүлэг авдаг байжээ. (Fu Wi Kang, 1999) Тухайн үед үйлчилж байсан эрх зүйн хэм хэмжээнүүдэд өвчлөл, эмч, тантай холбоотой зүйлүүдийг хуульчилж, тусгагдсан байдлыг авч үзвэл **“Арван буянт номын цагаан түүх”**нд:

Зүрхний шүтээн босго

Шар дээлтнийг хаад ноёд бүү мөргүүл

Сүм хийдийн дэргэдүүр бүү авла

Бацаг санваар хичээн сахь

Зургаан үсгийг унш, Өвчнийг эмнүүл (Чоймоо et al., 2006) гэж тусгажээ.

Мөн Түмэдийн алтан ханы цаазад “...Жанчих ялыг хүн алсан, хүний бие эрхтэн, эрүүл мэндэд хохирол учруулсан, цээрт өвчин халдаасан зэрэгт оноож дотор нь жанчих, гурав жанчих, нэг хэсэг жанчих гэж ялгасан байна. (Алтангэрэл, 1999)

Алтан хааны цааз нь дан ганц хориглосон хэм хэмжээнд тулгуурласан биш бөгөөд эрх олгох, үүрэг болгох, урамшуулахад чиглэсэн заалтуудаас бүрдэж байжээ.

Тухайлбал: “Эмчилж эдгээвэл эмчийн ачийг хариул”, “ус шавартай газар болон түймрээс тэмээг гаргавал тэмээ бүрээс нэг хонь ав”, “төрийн элч хоёр сайд, хоёр зарцтай явна”, “толгой эргэж төөрсөн хүүхдийг хэн тусалж авчирваас нэг сайн морь ав” зэрэг заалтууд дээрх дүгнэлтийг батална. (Алтангэрэл, 1999)

Монгол-Ойрадын их цаазад “...боож үхэх хүн, төрсөн, өвчтэй хүнийг эмнэж эдгээвэл юу амласан болохул түүнийг нь ав” гэх заалтын

агуулга нь тухайн үеийн төрийн урамшуулах бодлого бөгөөд Их цаазын 12 зүйл анги буюу 10 гаруй хувьд нь төрийн энэрэнгүй бодлого, урамшуулах бодлого тусгагдсан байна. (Алтангэрэл & Энхээ, 2024)

“Халх журам”-ын Өртөөний тухай хуулийн 15 дугаар зүйлд “...Ер ноёдын чилээ мэдэх элч улаат ноёд болох ахул хэвт улаагаараа явах. Тасалбаас ер лугаа адил. Улаагүй ноёдын элч тасалсан ноёд эзгэн унаж бай. “Ноёдын чилээ мэдэх элч” гэдэг нь өвчтэй ноёныг эмчлэхээр явж буй элчийг хэлж буй. “Улаан ноён болох ахул хэвт улаагаараа явах” гэж тогтоогдсон тоо ёсоор улаа хэрэглэж явахыг хэлж буй. “Тасалсан ноёд эзгэн унах” гэдэг нь улаат ноёдын улааг тасалсныг хэлж буй бололтой. (Монгол Улсын Хууль зүйн яам, 1995)

Мөн Хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тухай хуулийн 156 дугаар зүйлд “...Бас дотогш орох орогочин ямар ч хол аянд нөхрөө өвдсөнийг эмчлэлгүй, эзгүй газар орхиж ирээд тэр хүн үхвэл тэмээгээр ор босгоод нэг есөн бод авах, эдгээвээс соёолон хязгаалан морь авч бай, 161 дүгээр зүйлд Аглаг зүүсэн төмөгийн сааланд шилэрлэж хүн үхвээс хүн, тэмээний нэгээр ор босгоод зуун анзуу өгөх. Шөл өгч эмчилтүгэй. Эдгэвээс яамбат хүнд тайлаг тэмээ, ямбагүй хүнд хязгаалан мориор төлөөс өгч бай. (Монгол Улсын Хууль зүйн яам, 1995) хэмээн тусгажээ.

Иргэний болон захиргааны эрх зүйн холбогдолтой зарим зүйлийн 177 дугаар зүйлд “...Яамбат хүн түлэгдээд эдгэвэл тэмээ морь хоёр өг. Ямбагүй бол морь өг, эдгэтэл шөл өгч эмчлээд ноёндоо тушааж тавь.

Тойн буюу палам болох тухай хуулийн 283 дугаар зүйлд “...Хуврагт гүрэм хийлгэж барьсан, эмч нарт өвчин үзүүлж барьсан юм өргүй. 287 дугаар

зүйл “...Өөр орон төвд, хятад мэт бус газраас ирсэн сахилгүй бөгөөд буяны явдалт эмч зурхайч лав мөн бол хуврагийн цаазын ёсоор ганц биеэ мэдэх. Өөрөө олсон юмаа авч очих. Өөр хэлт ийм хүнд гурван үйлээс бишид улаа шүүс өгөхгүй. 295 дугаар зүйлд “...Өөр орноос ирсэн тон бус бөгөөд буяны явдалт илбэчин, эмч, зурхайч мэтийн хүмүүс өөр бусдад тус хүргэж нийтээр дагаж явах ёстой цаазаар явбал зохино хэмээн тусгаж байжээ.

Дээрх бүгдээс үзэхэд “Их засаг хууль”-иас эхлэлтэй хууль цаазын бичиг, хуулиуд зан заншлын шинжтэй, үүрэг болгох, урамшуулахад чиглэсэн байжээ. Хэрэв өвчтэй хүнийг эмчлэлгүй орхих явдал үед ялын бодлоготой байхаар төдийгүй эмчилсэн үед шагнаж, урамшуулах хэм хэмжээ тусгагджээ.

Ламын гэгээн Лувсанданзанжанцан 1681 онд анхны эмчийн сургууль Мамба дацангийн суурийг тавьжээ. Энэ үеэс эхлэн шарын шашны сүм хийдийн дэргэд эмчийн сургуулиуд олноороо байгуулагдсан.

Манба дацангийн сургалтын чанарыг сайжруулах дэг жаягийг тогтоох талаар нэгдсэн журмаар анхааран тусгайлан арга хэмжээг авдаг байжээ. Жишээ нь 4-р Богдын Лүндэн зарлигт “Мамба нар жүд ши” ном, уншлагыг сайтар уншин боловсорч, эм найруулах, эм тавих, судал барих хийгээд эмийн судруудыг нарийн нягт заалган боловсрох хэрэгтэй” гэж онцлон заажээ.

Эмчийн тангаргаас дурдвал “...Тахилын эд хэмээн сэтгэ мэдэх лүгээ гурав байх бөгөөд эмийг шүтвэл хүссэн бүхнийг үүсгэх чандмань өвчнийг хялбархан арилгагч үхэш үгийн рашаан мэт хэмээн сэтгэлдээ сайтар тогтоон авах нь жинхэнэ эмч болдог. (Болд, 2013) Тухайн үеийн уламжлалт анагаах ухааны эмч нар хүмүүнд хор өгөх,

эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх, эм, тан өгөхгүй байх нь тангараг зөрчсөн гэж үзэж, хариуцлага хүлээлгэдэг байсан нь түүхэн баримтуудаас харагдаж байна.

Хоёрдугаар үечлэл /Богд хаант Монгол Улсаас Ардчилсан Монгол Улс хүртэлх/:

Анхны эмийн сан 1923 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулагдаж, мөн 1924 оны 10 дугаар сарын 25-нд Ардын засгийн газар, намын төв хорооноос тусгай шийдвэрлэн Нийслэл хүрээний Цээ вангийн хороо гэж байсан нэг жижиг ноёны хашаанд 2 тасалгаанд модон байшинд 15 ортой, нэг эсгий гэртэй, нэг морин тэрэгтэй, нэг орос эмч, нэг түвд эмчтэй арваад ажилтантай анхны эмнэлэг ажиллаж эхэлжээ. (Болд, 2006)

Хууль бусаар эм худалдаалах явдалтай тэмцэж байсан түүхэн уламжлалыг авч үзвэл энэ гэмт хэрэгтэй тэмцэх үүднээс 1925 онд “Хүрээнд байсан хувийн эм найруулах газруудыг журамлан, улсын болгох тухай хэлэлцэн шийдвэрлэж” байсан нь архивын баримт бичигт тусгагдан үлдсэн. (Азжаргал, 2018)

Богд хаант Монгол Улсын үеэс дээрх төрлийн харилцааг хууль тогтоомжуудад тусгаж эхэлсэн төдийгүй эмийг хууль бусаар найруулах, худалдах, хэрэглэх, хадгалах, түгээх явдлыг гэмт хэрэгт тооцон, хуульчилсан.

Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин энэ үеэс бүрдэлдэн, эхлэл суурь тавигдаж, энэ төрлийн гэмт хэргийг одоо үйлчилж буй Эрүүгийн хуулийн зүйл заалтын агуулга, бүтэцтэй дөхөм, ижил төсөөтэй байдлаар анх Зарлигаар





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠰ

тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт тусгагдсан. Үүнд:

33 дугаар бүлэг ёслолын цаазын бүлэгт хааны хэрэглэх эм, зооглох юмыг базаахад ташаарах нь: “Хааны хэрэглэх эмийг нийлүүлэхэд уг эмийн найруулгын ёсоор нийлүүлээгүй жич эмийг битүүмжилж нэрийг бичихэд ташаарах болбоос эрхэлсэн эмчийг зуун ташуураар занч, эмийг найруулсан сонгосон нь ташаарч сайнгүй болбоос ерэн ташуур занч хааны зооглох юм базаахад зохилдохгүй юмыг ташааран нийлүүлбээс тогоочийг зуун ташуураар занч, зооглох юм ариунгүй болбоос наян ташуураар занч, зооглох юм ариунгүй болбоос наян ташуур занч, зассан сонгосон нь сайнгүй болбоос жаран ташуур занч хэрэв амталж үзэхгүй болбоос тавин ташуур занч.

Захирах заах түшмэлийг аливаа эмч тогоочийн ялаас хоёр зэрэг хорогдуулагтун” (Анх-Ирээдүй, 2017) хэмээн хааны хэрэглэх эмийг зохих тун, найрлагын дагуу найруулаагүй, буруу найруулсан дээрх эм нь сайн үр дүн үзүүлээгүй, эмийг буруу хадгалсан, буруу эм сонгосон бол уг эмийг найруулсан эмчид хариуцлага хүлээлгэхээр хуульчилж, тусгаж өгсөн нь Монголчууд эм хэмээх бодисын үйлчлэл, хор нөлөө зэрэг эмнэл зүйн шинжийг сайтар мэддэг байсны баталгаа юм.

Дээрх хуулийн хэм хэмжээ нь эмийг буруу найруулсан /үйлдвэрлэсэн/-аас үүсэх хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх, эмийг хууль бусаар найруулж түүний улмаас бусдад хор хохирол учрахаас хамгаалсан, тусгай субъектийн шинжтэй зохицуулалт болсон гэж дүгнэж болох юм.

49 дүгээр дэвтэрт муу тарни эм хийж хадгалуулаад хүнийг алах: **Нэгэн зүйл.** Аливаа хүнийг албаас болох тарни, эмийг нийлүүлэн хийх,

нуун хадгалуулах ба жич, хүнд хийх хадгалахыг сургах болбоос цөм буудан ал. Эрхгүй хэрэглэж хүн алсныг нь аваас хэрэв отог, багийн дарга айл гэрийн хүн мэдээд гарахгүй болбоос зуун ташуур занч. Мэдэхгүй болбоос оноохгүй. Гэрчилсэн барьсан хүнд албаны мөнгө хорин ланг шагнан өг. Увдислан муу сайн орох ба хатуу бичиг хийж зүүж хүнийг алсугай хэмээх нь болбоос зүгээр хүн хөвгүүн жич, боол шивэгчин үнэлсэн хүн дээд үе доод аливааг аргаар алсугай хэмээн явж хор хийсэнгүй ёсоор хэлэлц. Түүний учирт үхвээс аливааг уг аргаар алсан цаазын ёсоор оноогтун. Гагцхүү хүнийг өвтгөж зовоосугай хэмээх нь хүнийг алах сэтгэлгүй болбоос аргаар алсугай хэмээн явж хор хийсэнгүй ялаас хоёр зэрэг хорогдуул. Эм худалдан авч хэрэглэсэнгүй болбоос зуун ташуур занчаад дөчин өдөр дөнгө дөнгөлүүл. Учрыг мэдэж эм худалдан өгвөөс ялт хүний адил ялла. Үхэхэд хүрвээс зэрэг холдуул. Мэдэхгүй болбоос оноохгүй.

Дээрх цааз нь хүнийг алахаар эмийг нийлүүлэх, хадгалуулах, хүнд хийх, хадгалахыг сургавал цаазын ял оноож, ялын бодлого хатуу байсныг харуулж байна. Мөн дээрх гэмт хэргийг мэдээлээгүй хүнд зуун ташуурын хариуцлага оногдуулдаг байжээ.

Нэгэн зүйл: Аливаа хүн хор эм худалдахыг шүүж учир мэдэж худалдахыг нь басхүү цаазын бичгийн ёсоор ялт хүний адил ял оноохоос гадна хэрэв учрыг хянахгүй гагцхүү ашгийг хичээж дэмий худалдаж хүний амины хэрэг гарч ирэхэд хүргүүлбээс хэдий учрыг хэмээвч мөн худалдсан хүнийг зүйлгүйгээр явсан хүнд цаазын бичгийн ёсоор наян ташуур занчигтун.

Нэгэн зүйл: Аливаа хор, эмээр хулгана, гөрөөчийг алахад ташааран хүнийг алсан хэрэг, хэрэв хүний асар хүрэхгүй эсвээс мал тэжээвэр идүүлэх газарт эм тавьж санамсаргүй хүнийг

алсан үнэхээрийн чих, нүд, санал бодлогоор хүрэхгүйг нь болбоос хүнийг эндэгдэн алсан цаазын бичгийн ёсоор золио авагтун, хэрэв хүний дараачаар өнгөрөн явах газарт тавьж түүний учирт хүнийг албаас учиргүй хүний суусан гэрийн зүг чавхдан харвасан цаазын бичгийн ёсоор зуун ташуур занчиж жаран өдөр дөнгө дөнгөдүүл. Басхүү яг хувцаслах мөнгө арван лан хөөн авч өгөгтүн (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2011) хэмээн хуульчилсан нь өнөөгийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20 дугаар зүйлийн 20.14-т заасан “Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах” гэмт хэргийг маш оновчтой, агуулгын хувьд дөхөм байдлаар хуульчилсан явдал байлаа.

Тухайлбал хүний бие махбодод хортой эм бэлдмэл үйлдвэрлэх, түүнийгээ хадгалах, бусдад худалдах, худалдсаны улмаас бусдын амь нас эрүүл мэндэд хор уршиг учирсан, мөн эмийг хуурамчаар үйлдэх, уг эмийг хуурамч эсхүл хүний амь нас эрүүл мэндэд хохирол учруулах үйлчилгээтэйг гэдгийг мэдсээр байж худалдан авсан, худалдсан, мэдсэн ч хэлээгүй этгээдэд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Үүнээс гадна хортой эм ашиглаж ан, гөрөө хийх, мал алах зэрэг зорилготой байсан ч гэм буруугийн андуурлын улмаас хүний амь нас хохироосон болон хүнд гэмтэл учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан төдийгүй оногдуулах ялын бодлогыг чангатгаж өгсөн нь дээрх гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, уг үйлдлийн улмаас хүн ба төрийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх явдлаас эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалахад чухал алхам болжээ.

Тухайн үед Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилж байсан Шүүх цаазын бичгүүд болон Эрүүгийн хуулиудад энэ төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааснаас үзэхэд түүхэн цаг хугацаанд эмийн эргэлттэй холбоотой харилцаа нь төрийн хяналтад хуулийн зохицуулалттай байсан нь судалгаанаас харагдаж байна.

Тухайлбал: 1926, 1929 онуудын Шүүх цаазын бичигт “Аливаа эмийн зүйлийг найруулах ба эм худалдах газраас бусад дор худалдах тухай дүрэм зааврыг зөрчигсдийг 100 төгрөг хүртэл торговол зохино” хэмээн Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэргийн шинжтэй харилцааг зохицуулж байснаас гадна “Аливаа хорын зүйл буюу мөн зүйл оролцсон хатуу эм ба хар тамхийг албан газрын зөвшөөрөлгүйгээр бусдад худалдахаар хадгалах буюу худалдагсдын уг зүйлүүдийг албадан хурааж 3 сар хүртэл хорих буюу 150 төгрөг хүртэл торговол зохино” хэмээн хар тамхи буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар худалдаалахыг хориглосон зүйл заалтыг тусгаж байжээ.

Харин 1961 оны Эрүүгийн хуулийн 185 дугаар зүйлд “Хүний биед хүчтэй нөлөөлөх, хордуулах, ухаан алдуулах бодисыг зөвшөөрөлгүй найруулж бэлтгэх, худалдаж борлуулах зорилгоор хадгалах буюу олж авах түүнчлэн хүний биед хүчтэй нөлөөлөх хордуулах, ухаан алдуулах бодисыг хадгалах, тавьж олгох, бүртгэх, тээвэрлэх, явуулах талаар тогтоосон дүрмийг зөрчвөл ...” Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан (Адъяабазар, 1998) бол 2002 оны Эрүүгийн хуульд “Эмийн сангийн үйл





ᠮᠣᠩᠭᠡᠯᠡ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

ажиллагааг эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм бэлдмэлийг их хэмжээгээр борлуулсан...”, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол...” гэж хүндрүүлэхээр заасан нь ард түмний эрүүл мэндийг хамгаалахад чухал алхам болсон.

1926 оны шүүх цаазын бичиг:

85 дугаар зүйлд “Аливаа эмийн зүйлийг найруулах ба эм худалдах газраас бусад худалдах тухай дүрэм зааврыг зөрчигсдийг зуун төгрөгөөр торговоос зохино” хэмээн хуульчилсан нь эм, эмт бодис, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэлийг албан ёсны зөвшөөрөлтэй эм худалдах бусад газар худалдахыг хориглосон агуулгатай зохицуулалт болж, эм бол хадгалах, худалдах, үйлдвэрлэх тусгай горим, нөхцөл шаардсан онцгой зүйл учир хууль бусаар үйлдвэрлэх, зориулалтын бус нөхцөлд ил задгай худалдах нь хүн амын эрүүл мэндэд аюултай тул хуулийн энэхүү зохицуулалт нь дээрх үйлдлийн улмаас хүний эрх ашиг сонирхол хохирохоос хамгаалсан шинжтэй эрх зүйн зохицуулалт болсон.

Мөн 86 дугаар зүйлд “Аливаа хорын зүйл буюу мөн зүйл оролцсон хатуу эм ба хар тамхийг албан газрын зөвшөөрөлгүйгээр бусдад худалдахаар хадгалах буюу худалдагсдыг уг зүйлүүдийн албадан хурааж гурван сар хүртэл хорих буюу зуун тавин төгрөг хүртэл торговол зохино” гэж тусгасан нь дээрх 85 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй агуулгын хувьд ижил боловч хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх болон бусад хүнд хор уршиг учруулахуйц хортой найрлага бүхий эм бэлдмэлийг хууль бусаар худалдаалахыг хориглосон нь онцлог заалт болжээ.

1929 оны Шүүх цаазын бичгийн 90 дүгээр зүйлд “Аливаа эмийн зүйлийг найруулах ба эм

худалдах газраас бусдад худалдах тухай дүрэм журмыг зөрчигдсөдийг 100 төгрөг хүртэл торговоос зохимой” гэж хуульчилсан нь 1926 оны шүүх цаазын бичигт гэмт хэрэгтэй агуулга, ялын бодлогоороо адил байна.

91 дүгээр зүйлд Аливаа хорын зүйл буюу мөн зүйл оролцсон хатуу эм ба хар тамхины зэрэг хүмүүнийг биед онц хор бүхий зүйлүүдийг албаны газрын зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах буюу хэрэглэхээр хадгалах ба худалдаалагсдын уг зүйлүүдийг албан хураамж 200 төгрөг хүртэл торговоос зохимой” хэмээн хуульчилж, 92, 93 дугаар зүйлд хүндрүүлэх нөхцөлийг тусгаж өгснөөр шинэлэг цааз болсон байна.

1942 оны Эрүүгийн хуулийн 116 дугаар зүйл: Хүний мэдрэлийг алдагдуулах хортой /хар тамхи, кокайна, морфи, эфира зэрэг/ зүйлүүдийг хууль бусаар хадгалах, худалдах зорилгоор бэлтгэх мөн түүнчлэн тэдгээр зүйлүүдийг худалдвал нэгэн жил хүртэл хугацаагаар хорих буюу албадан ажил хийлгэж уул зүйлүүдийг хураавал зохино.

Мөнхүү явдлыг ажил амьдарлага болгон үйлдэх, мөн түүнчлэн энэ зүйлүүдийг худалдах буюу хэрэглэхийн тулд тусгай орон сав бэлтгэн үйлдвэл 3 жил хүртэл хугацаагаар хорьж бүх хөрөнгийг хураавал зохино.

161 дүгээр зүйл: Бусдыг буруугаар эмчилбэл 2 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ. Мөнхүү явдлыг үйлдсэнээс хүнд өвчин тохиолдсон буюу ямар нэгэн биеийн эрхтэнг эвдэх зэргээр хүнд бэрх байдалд учруулсан буюу эсвэл амь биеийг үрэгдүүлсэн байвал 100 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

Тайлбарлах нь: Хувьсгалын эсэргүү зорилгоор бусдыг санаатайгаар буруу эмчилбэл гэмт этгээдийг 63 дугаар зүйлийн ёсоор шийтгэнэ. Хэрэв

санаатайгаар боловч хувьсгалын эсэргүү зорилгогүй харин өөр нэгэн шалтгаанаар тийнхүү буруу эмчилсэн байвал 148 дугаар зүйл ба 155 дугаар зүйлийн ёсоор шийтгэвэл зохино хэмээн тусгаж байсан.

1961 оны Эрүүгийн хууль нь 1942 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх зорилгоор уг хуулиар гэмт хэрэг гэж үзэж байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинж, чанараа алдсан гэх үндэслэлээр эрүүгийн хуулиас хасаж, нийгэмд аюулгүй үзэгдлийг шинээр гэмт хэрэгт тооцон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн зарим төрлийн гэмт хэргийн нэр томьёо, бүтэц, агуулгад өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан.

Дээрх нэмэлт, өөрчлөлтөөр **185 дугаар зүйл /Хүний биед хүчтэй нөлөөлөх, хордуулах, ухаан алдуулах бодисыг найруулж бэлтгэж, борлуулах/-ийн**

“...а.Хүний биед хүчтэй нөлөөлөх, хордуулах, ухаан алдуулах бодисыг тусгай зөвшөөрөлгүй найруулж бэлтгэх, худалдаж борлуулах, мөн худалдаж борлуулах зорилгоор хадгалах буюу олж авах, түүнчлэн хүний биед хүчтэй нөлөөлөх, хордуулах, ухаан алдуулах бодисыг хадгалах, тавьж олгох, бүртгэх, тээвэрлэх, явуулах талаар тогтоосон дүрмийг зөрчвөл нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу 500 төгрөг хүртэл торгоно.

“...б.Энэ гэмт хэргийг удаа дараа үйлдсэн буюу ноцтой хор хохирол учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ” гэсэн агуулга бүхий шинэ хэм хэмжээг гэмт хэрэг хэмээн эрүүгийн хуульд хуульчилж, ялын бодлого чанга байсныг харуулж байна.

Хүний биед хүчтэй нөлөөлөх, хордуулах, ухаан алдуулах бодис нь хүний эрүүл мэнд, амь насанд аюултай учраас ийм бодисуудыг найруулан бэлтгэх, олж авах, хадгалах, худалдаж борлуулах зэрэг үйлдлүүд нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах хуулийн эсрэг чиглэгдсэн гэмт хэрэг болой. Дээрх бодисуудыг тусгай зөвшөөрлөөр шинжлэх ухаан, эмнэлгийн шаардлага хэрэгцээнд зориулан найруулан бэлтгэдэг байна.

1961 оны Эрүүгийн хуульд тусгалаа олсон энэхүү хэм хэмжээ сэтгэцэд нөлөөлөх, ухаан алдуулах бодис хэмээн нэлээд өргөн агуулга бүхий байдлаар хуульчлагдсан нь өнөөгийн үйлчилж буй гэмт хэрэгтэй ижил төстэй харилцааг зохицуулж, хүний биед хүчтэй нөлөөлөх, ухаан алдуулах, эм болон бусад бодисын хууль бус эргэлтээс иргэн төрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалсан шинэлэг зохицуулалт болсноороо 1942 оны Эрүүгийн хуулиас давуу талтай болж, дээрх үйлдлийг Улсын дээд шүүхээс албан ёсоор хуулийн хүрээнд оновчтой тайлбарлаж байсан.

Мөн **1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд** одоогийн Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэргийн шинжтэй харилцааг дараах байдлаар хуульчилж өгсөн байна.

Яг тухайлсан хууль бусаар эмтэй холбоотой үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй боловч агуулгаараа 74 дүгээр зүйл Хар тамхи, мансууруулах болон хордуулах бодис, хууль бусаар хил нэвтрүүлэх харилцааг, 106 дугаар зүйл Өнгөний өвчин халдаах, 107 дугаар зүйл Өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх, 108 дугаар зүйл Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх, Шаардлага





Хууль сахиулахуй

хангаагүй нөхцөлд хүний цус, эд, эрхтэн бэлтгэсэн, шилжүүлэн суулгасан, 251 дүгээр зүйлд Хууль бусаар эмчлэх, 252 дугаар зүйлд Тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх, дархлаажуулалтын талаар тогтоосон журам зөрчих, 253 дугаар зүйлд Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, 254 дүгээр зүйлд Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийн шинжүүдэд хамааруулж гэмт хэрэгт тооцдог байсан.

Мөн нөгөөтээгүүр энэ үед дэлхийн өөрчлөлт, шинэчлэлтийн үе байсан. Оросын холбооны улс задарч унан, дэлхий нийтээр шилжиж, улс орнуудын хил хязгаар нээлттэй болж, ард иргэд чөлөөтэй зорчдог болсон. Ардчилсан үзэл, нийгмийн эхлэл тавигдсантай холбоотойгоор эмийн хууль бус эргэлт цэцэглэж эхэлсэн.

Гуравдугаар үечлэл:
/Ардчилсан Монгол Улсын /1990 оноос хойших/ өнөөг хүртэлх цаг үе:/
2002 оны Эрүүгийн хуульд “Эмийн сангийн үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм, бэлдмэлийг их хэмжээгээр борлуулсан, түүнчлэн энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол...” гэж ял хүндрүүлэхээр заасан нь Хүн амын эрүүл мэнд, эрх ашгийг эрүүгийн хуулиар хамгаалах чухал алхам болсон.

Гэвч орчин үед зарим байгууллага, аж ахуйн нэгж, иргэд зөвшөөрөлгүй, хяналтгүйгээр эмийн үйлдвэрлэл, худалдаа, бизнес эрхлэх, импортоос гадна оруулж ирэх, хугацаа нь дууссан, Монгол улсад бүртгэлгүй, худалдахыг хориглосон эмүүдийг хувиараа худалдах, түгээх явдал хавтгайрснаас ийм эмийг хэрэглэсэн,

иргэд, эрүүл мэнд, амь насаараа хохирох явдал түгээмэл гарах болсон нь эрх зүйн зохицуулалт нийгмийн харилцаагаа гүйцэхгүй байгааг илэрхийлж, шинээр зохицуулалт хийхийг шаардах болсон.

Аливаа хууль үйлчлэх явцад хийдэл, хэрэглэхэд хүндрэлтэй бусад асуудал тогтмол гарч түүнийг арилгах зарим хэм хэмжээг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага гардаг нийтлэг зүй тогтлын дагуу дээрх нөхцөл байдлыг харгалзан Улсын Их хурлаас 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Эмийн сангийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах” гэсэн 198-р зүйлд заасан гэмт хэргийг “Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх” гэж нэр, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг нь өөрчлөн найруулж дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

Эрүүгийн хуулийн 198 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортолсон, хадгалсан, худалдсан, түгээсэн бол” хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, 2 дахь хэсэгт “Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагаа явуулсан” бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял

шийтгэнэ, 3 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж ял хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилсан нь өмнөх эрүүгийн хуультай харьцуулахад оновчтой зохицуулалт болсон байна.

Учир нь нэмэлт өөрчлөлтөөр 198 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагаа явуулсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнөх эрүүгийн хууль тусгагдаагүй цоо шинэ агуулгатай, иргэдийн эрх ашиг, эрүүл мэндийг Эрүүгийн хуулиар хамгаалсан, эрх зүйн хийдлийг арилгасан зохицуулалт болсон нь сайн хэдий ч хууль бусаар эм, худалдаалах явдал нь нийгэмд тархсан түгээмэл үзэгдэл, энэхүү үзэгдэлд хандах иргэдийн сэтгэлгээ зэрэг нөхцөл байдлаас хамаарч хуулийн хэрэгжилт үр нөлөөгүй үргэлжилсээр байна. (Нарангарав, 2009)

Үүний шалтгаан нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 198 дугаар зүйлийн 198.2-т “Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээсэн” тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр “Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй”-гээр хуульчилсан нь энэ зүйл ангийг практикт хэрэглэхэд хүндрэл учруулсан. Өөрөөр хэлбэл зохих зөвшөөрөлгүй этгээд эмийг худалдаалсан, үйлдвэрлэсэн, түгээсэн үйлдэл хийснээр төгсдөг, ямар нэгэн хор уршиг учирсан байхыг шаардахааргүй хуульчилсан нь учир дутагдалтай болж манайд бий болсон нөхцөл байдалд нийцэхээргүй болж, эцсийн үр дүнд эрүүгийн хариуцлага гараагүй байх зарчмыг үгүйсгэдэг үр дагавартай. (Анх-Ирээдүй, 2017)

Улсын Их Хурлаас 2012 онд Эмийг хууль бусаар үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх, гэмт явдалтай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлж эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, оноох торгуулийн хэмжээ буюу хариуцлагын хэмжээг өндөрсгөж нэр томъёог боловсронгуй болгох ажлын хүрээнд 2015 оны Эрүүгийн хуульд “Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх гэмт хэргийг хуульчилсан байдлыг авч үзвэл:

Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх)-д "Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, малын эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортолсон, худалдсан, түгээсэн...", "Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр явуулсан...", "хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, их хэмжээний хохирол учирсан бол...". "Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол...", "Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол... ял хүндрүүлэхээр заасан нь хүн амын эрүүл мэнд, эрх ашгийг эрүүгийн хуулиар хамгаалах чухал алхам болсон.



МОНГОЛЫН ХУУЛЬ




ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠤᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

Мөн бас нэг шинэлэг зохицуулалт нь хуулийн этгээдэд Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг, дэлхийн Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн орчин цаг үеийн нөхцөлд тохирсон маш дэвшилттэй зохицуулалт оруулж ирсэн.

Харин 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж гэмт хэргийн халдлагын зүйлээс малын эм, биобэлдмэлийг хасаж, Зөрчлийн тухай хуульд зөрчилд тооцож шийтгэл оногдуулахаар тооцсон. Энэ нь Монгол орны малын генетикийн бодлогыг хамгаалахад чиглэгдсэн бодлогоосоо ухарсан алхам болсон.

Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжтэйгээр хуульчилсан. (Энхболд & Гантулга, 2024)

Эмийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг хууль тогтоомжид хуульчилж ирсэн байдалд үнэлэлт хийсэн харьцуулалтыг гарфикаар харуулбал:



Зураг 1. Хууль, тогтоомжид хуульчилж ирсэн харьцуулалт

Эмийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг хууль, тогтоомжид хуульчилж ирсэн байдалд үнэлэлт, харьцуулалт хийхэд **нэгдүгээр үечлэл** буюу “Эртний үе”-д **15%** буюу хуульчлагдсан байдал сул, **хоёрдугаар үечлэл** Богд хаант Монгол Улсаас Ардчилсан Монгол Улс хүртэлх үед **63%** буюу хуульчлагдаж ирсэн байдал дунджаас дээгүүр, **гуравдугаар үечлэл** Ардчилсан Монгол Улсаас өнөөг хүртэлх үед **87%**-тай буюу хууль тогтоомжид хуульчлагдаж ирсэн байдал ахисан боловч төдийлөн хангалттай биш гэж үзэж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

1.Эмийн хууль бус эргэлттэй тэмцэж ирсэн Монголын түүхэн уламжлалыг үндсэн гурван үечлэлд хуваан авч үзэх нь оновчтой гэж үзлээ. Тодруулбал: Эртний, Богд хаант улсын үеэс ардчилсан Монгол Улс хүртэл, Ардчилсан Монгол Улсаас хойш үе зэрэг болно.

Шинэ чулуун зэвсгийн үеэс нүүдэлчдийн анхны нэгдсэн улс Хүннү гүрэн байгуулагдсан МЭӨ209 он, түүнээс хойш МЭ1206 онд Монголын

нэгдсэн улс байгуулагдах хүртэл 1500-гаад жилийн хугацаанд Монголын уламжлалт анагаах ухаан буюу эм, эмч, анагаагч бодисууд зэрэг зүйлүүд цаг хувьсахын хирээр хөгжиж, хувьсан иржээ. Дээрх цаг хугацаа, түүхийн эх сурвалжуудад эмнэлгийн тусламж үзүүлээгүй, эсвэл буруу эмчилсэн эмч, оточ, домч нарт ямар хариуцлага хүлээлгэдэг байсан талаар нарийвчлан тусгагдаагүй байсан.

2. Чингис хаан “Их засаг” цаазад эмч, өвчин, эмчлэх, түүнтэй холбоотойгоор урамшуулах, эмчилж чадаагүйг нь шийтгэх зэрэг эрх зүйн хэм хэмжээг анх тусган өгч, зөвхөн цэргийн стратеги, удирдлагын талаар төдийгүй анагаах ухаан, эмнэлгийн салбарт ч өндөр ач холбогдол өгч, үүнийг бүхэл бүтэн улс оронд чухал хэсэг нь болгосон байна.

“Их засаг хууль”-иас эхлэлтэй хууль цаазын бичиг, хуулиуд зан заншлын шинжтэй, үүрэг болгох, урамшуулахад чиглэсэн байна. Хэрэв өвчтэй хүнийг эмчлэлгүй орхин явдал үед ялын бодлоготой байхаар төдийгүй эмчилсэн үед шагнаж, урамшуулах хэм хэмжээ тусгагджээ. Тухайн үеийн уламжлалт анагаах ухааны эмч нар хүмүүнд хор өгөх, эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх, эм, тан өгөхгүй байх нь тангараг зөрчсөн гэж үзэж, хариуцлага хүлээлгэдэг байсан нь түүхэн баримтуудаас харагдаж байна.

3. Богд хаант Монгол Улсаас эхлэн Эмийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдтэй тэмцэж тухайн үед шүүх цаазын бичгүүдэд хуульчилж эхэлсэн байна. Энэ үеэс эмийн хууль бус эргэлттэй холбоотой төрлийн харилцааг хууль тогтоомжуудад тусгаж эхэлсэн төдийгүй эмийг хууль бусаар найруулах, худалдах, хэрэглэх, хадгалах, түгээх явдлыг гэмт хэрэгт тооцон, хуульчилж эхэлсэн байна.

Тухайлбал: 1926, 1929 онуудын Шүүх цаазын бичигт эмийн хууль бус эргэлттэй холбоотой харилцааг зохицуулж байснаас гадна хар тамхи буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар худалдаалахыг хориглосон зүйл заалтыг тусгаж байжээ. Харин 1961 оны Эрүүгийн хуулийн 185 дугаар зүйлд “Хүний биед хүчтэй нөлөөлөх, хордуулах, ухаан алдуулах бодисыг зөвшөөрөлгүй найруулж бэлтгэх, худалдаж борлуулах мөн худалдаж борлуулах зорилгоор хадгалах буюу олж авах түүнчлэн хүний биед хүчтэй нөлөөлөх хордуулах, ухаан алдуулах бодисыг хадгалах, тавьж олгох, бүртгэх, тээвэрлэх, явуулах талаар тогтоосон дүрмийг зөрчвөл ...” Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан (Адъяабазар, 1998) бол 2002 оны Эрүүгийн хуульд “Эмийн сангийн үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм бэлдмэлийг их хэмжээгээр борлуулсан...”, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол...” гэж хүндрүүлэхээр заасан нь ард түмний эрүүл мэндийг хамгаалахад чухал алхам болсон.

Тухайн үед Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилж байсан Шүүх цаазын бичгүүд болон Эрүүгийн хуулиудад энэ төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааснаас үзэхэд түүхэн цаг хугацаанд эмийн эргэлттэй холбоотой харилцаа нь төрийн хяналтад хуулийн зохицуулалттай байсан нь судалгаанаас харагдаж байна.

Мөн нөгөөтээгүүр 1986 оны үед дэлхийн өөрчлөлт, шинэчлэлтийн үе байсан. Оросын холбооны улс задарч унан, дэлхий нийтээр шилжиж, улс орнуудын хил хязгаар нээлттэй болж, ард иргэд чөлөөтэй зорчдог болсон.





Хууль сахиулахуй

Ардчилсан үзэл, нийгмийн эхлэл тавигдсантай холбоотойгоор эмийн хууль бус эргэлт цэцэглэж эхэлсэн.

2015 оны Эрүүгийн хуулийн мөн бас нэг шинэлэг зохицуулалт нь хуулийн этгээдэд Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг, дэлхийн Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн орчин цаг үеийн нөхцөлд тохирсон маш дэвшилттэй зохицуулалт оруулж ирсэн.

Харин 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж гэмт хэргийн халдлагын зүйлээс малын эм, биобэлдмэлийг хасаж, Зөрчлийн тухай хуульд зөрчилд тооцож шийтгэл оногдуулахаар тооцсон. Энэ нь Монгол орны малын генетикийн бодлогыг хамгаалахад чиглэгдсэн бодлогоосоо ухарсан алхам болсон.

Өнөө үед эмийн худалдаа, хууль бус эргэлттэй холбоотой асуудал олон нийтийн анхаарлын төвд байсаар ирлээ. Энэ нь 2024 оны 04 дүгээр сард Улсын Их Хурлаас Эмийн хүртээмж, үнэ чанарын асуудлаарх нээлттэй сонсгол зохион байгуулсан явдлаар дүгнэж болно.

Мөн дэлхий нийтийг цочроосон халдварт өвчний вакцин хүртэл дэлхийн улс, орнуудын мэтгэлцээний тавцан болж хувирч байна. Манай улс дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлж эрх зүйн орчин, зохион байгуулалтыг өөр шатанд шинэчлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

Fu Wi Kang, L. Z. (1999). *A General History of Chinese Medicine*. Chine: People's medical Publishing House.

Адъяабазар, Д. (1998). *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.

Азжаргал, А. (2018). Магистрын зэрэг горилсон судалгааны ажил.

Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. Улаанбаатар хот: Хууль сахиулахын их сургууль.

Алтангэрэл, Т. (1999). *XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд*. Улаанбаатар хот: Өргөө хэвлэл.

Алтангэрэл, Т., & Энхээ, Ц. (2024). *XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.

Анх-Ирээдүй, Г. (2017). Монгол Улсын Хууль зүйн сургууль. *Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал*. Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль хэвлэл.

Болд, Ш. (2006). *Монголын Уламжлалт анагаах ухааны түүхэн уламжлал*. Улаанбаатар хот: Admon printing.

Болд, Ш. (2013). *Монголын Уламжлалт анагаах ухааны түүхэн уламжлал*. Улаанбаатар хот: Admon printing.

Монгол Улсын Хууль зүйн яам. (1995). *Халх журам*. Улаанбаатар: Admon printing.

МУҮИС, Х. з. (1995). *Эзэн богд Чингисийн "Их засаг"*. Улаанбаатар хот: Өргөө хэвлэл.

Нарангарав, Н. (2009). Хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн өнөөгийн байдал анхаарах асуудал. *Гэмт явдалтай тэмцэх асуудал*, 30(№4), 30.

- Ням-Осор, Н. (2022). *Их засаг хуулийн тайлбар 1 дүгээр боть*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.
- Уранчимэг, М. (2006). Эм зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. *Эмийн үндэсний үйлдвэрлэлийн чанарын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлууд*. Улаанбаатар хот: Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль.
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2011). *Монгол Улсын Эрүүгийн хууль*

- тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.
- Чоймоо, Ш., Баярсайхан, Б., & Төрдалай, Р. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал "Арван буянт номын цагаан түүх"*. Улаанбаатар хот: Admon printing.
- Энхболд, Б., & Гантулга, С. (2024). *Эрүүгийн эрх зүй: тусгай анги /сурах бичиг/*. Улаанбаатар: Мөнхийг үсэг.

